



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 57306

Улаанбаатар хот

Г С.Даваадоржид сахилгын шийтгэл  
ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.16, 48 дугаар зүйлийн 48.1.1 дэх заалт, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны А/1300 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Улсын бүртгэлийн байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам”-ын 10 дугаар зүйлийн 10.4, 10.6, 10.7 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Самбуунийн Даваадорж нь Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг зөрчсөн нь Хяналт шалгалтын газрын 2023 оны 35 дугаартай дотоод албан бичиг, Авлигатай тэмцэх газрын 2023 оны “Зөрчил арилгуулах болон хариуцлага тооцуулах тухай” 06/4837 дугаартай албан бичиг, өөрийн гаргасан тайлбараар тогтоогдсон тул түүнд 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Өдөр тутмын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хэрэгжүүлж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг улсын бүртгэгч С.Даваадоржид үүрэг болгосугай.

3. Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахих талаар анхааруулахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/, Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс /Д.Оюунбилэг/, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т үүрэг болгосугай.

4. Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

1102091166